



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2022 оны 15 сарын 25 өдөр

Дугаар Д/М/2

Арвайхээр

Дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2020 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн “Өвөрхангай аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/03 дугаар тогтоолын нэгдүгээр хавсралтын 1.3.2, Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн 61 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.1.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Бразил улсын Кашаис ду Сул (Caxias do Sul) хотод зохион байгуулагдах зуны Дифлимдийн XXIV наадамд оролцох тамирчин Н.Эрхэмбаяр, Б.Оюундэлгэрэх, Дасгалжуулагч Э.Баттүшиг нарын тэмцээний зардалд 6,000,000 (зургаан сая) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дээрх арга хэмжээнд шаардагдах 6,000,000 (зургаан сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6222 11 0303

D:My Doc. Zahiramj. Zasag darga